



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

### Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” А/155 дугаар захирамжаар батлагдсан газрын дүрмийн 7.1.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлагдсантай холбогдуулан тус газрын бүтэц, орон тоо өөрчлөгдөж газрын албан тушаал (ажлын байр)-ын жагсаалтыг шинэчлэн баталсан тул албан тушаалын тодорхойлолтуудыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Содномдэмбэрэл Захиргаа, санхүүгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: В.Батчимэг Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга

Э.Мөнхзул Бодлогын баримт бичгийн тайлан, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн

С.Туул Маркетинг сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Нарийн бичиг:

Д.Оюун-Эрдэнэ Хүний нөөц, ёс зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

2.Боловсруулсан албан тушаалын тодорхойлолтуудыг Төрийн албаны зөвлөлд хянуулж, батлуулахыг ажлын хэсэг /Х.Содномдэмбэрэл/-т даалгасугай.

ДАРГА *Д.Батсүх* Д.БАТСҮХ



1150500034